# ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

# САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Хөвсгөл аймгийн Эрдэнэбулган сумын ЗДТГ-ын 2022 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн аудитын тайлан

**Аудитын код: ХӨА-2023/51/НА-СТА-ТШЗ**

Цахим хуудас: www.audit.mn

Хөвсгөл аймаг

2023 он


Дарга, тэргүүлэх аудитор: А.Эрдэнэбаатар

Утас: 88883317 Цахим хаяг: erdenebaatara@audit.gov.mn

Аудитын менежер: Б.Тэгшдэлгэр

Утас: 99900662 Цахим хаяг: tegshdelgerb@audit.gov.mn

Аудитор: С.Гансүх

Утас: 95908400 Цахим хаяг: gansukhsa@audit.gov.mn


Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

**АГУУЛГА**

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ ..... 4
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ ..... 6
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА ..... 12
3.4 Санхүүгийн тайлангийн тодруулга ..... 13
3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв ..... 13
4.1 Ерөнхий зүйл ..... 15
4.2 Материаллаг байдал ..... 15
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт ..... 15
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал ..... 15
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт ..... 15
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт ..... 16
4.5.1 Завсрын аудитын талаар ..... 16
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал ..... 16
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ ..... 16
5.1 Төлбөрийн акт ..... 16
5.2 Албан шаардлага ..... 16
5.3 Зөвлөмж ..... 16

я

## Товчилсон үгийн жагсаалт

| | |
|---|---|
| УСНББОУС | Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт |
| АДБОУС | Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт |
| ТӨБЗГ | Төрийн Өмчийн Бодлого Зохицуулалтын Газар |
| ЗДТГ | Засаг Даргын Тамгын Газар |

ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

АЗДТГ-ын байр, А корпус 3 давхар,
Мөрөн сум, Хөвсгөл аймаг, 67120
Утас/факс:7038 3793, Цахим шуудан:khuvsgul@audit.gov.mn
Цахим хуудас: www.audit.mn

2023.02.24 № 01/93
танай ______ -ны № ______ -т

ЭРДЭНЭБУЛГАН СУМЫН ЗАСАГ
ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН ДАРГА
М.ОЮУМАА ТАНАА

## Хараат бус аудиторын дүгнэлт

### Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Эрдэнэбулган сумын ЗДТГ-ын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Эрдэнэбулган сумын ЗДТГ-ын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

### Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

### Асуудлыг онцолсон хэсэг

Эрдэнэбулган сумын Засаг даргын Тамгын газар тайлант онд Засгийн газрын 2020 оны 9 дүгээр тогтоолын дагуу орон нутгийн өмчийн эд хөрөнгийн улсын үзлэг, тооллого зохион байгуулах хүрээнд байгууллагын үндсэн хөрөнгийг тоолж баталгаажуулсан байна.

### Аудитын гол асуудал

Эрдэнэбулган сум нь Нэмэлт санхүүжилтийн дансаар 205,634.9 мянган төгрөгийг хүлээн авч далан барих, хогийн цэг нүүлгэн шилжүүлэх ажлыг хийж гүйцэтгэсэн байна.

### Бусад асуудлын хэсэг

Эрдэнэбулган сумын Засаг даргын Тамгын газар нь 3 хөтөлбөр 9 арга хэмжээг хэрэгжүүлэн гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилт 92.0 хувиар үнэлэгдсэн байна.

### Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

### Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР А.ЭРДЭНЭБААТАР

## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/Төгрөгөөр/

| Дансны код | Балансын үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|---|---|---|---|
| **1** | **ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН** | **77,409,456.80** | **98,290,164.80** |
| **33** | **АВЛАГА** | 1,250,000.00 | 1,250,000.00 |
| **335** | **Бусад авлага** | 1,250,000.00 | 1,250,000.00 |
| 3352 | Хувь хүмүүсээс авах авлага | 1,250,000.00 | 1,250,000.00 |
| **35** | **БАРАА МАТЕРИАЛ** | 71,159,456.80 | 92,040,164.80 |
| **351** | **Түүхий эд материал** | 1,998,700.00 | 1,998,700.00 |
| 35110 | Тусгай зориулалттай материал | 1,998,700.00 | 1,998,700.00 |
| **354** | **Хангамжийн материал** | 57,360,756.80 | 78,241,464.80 |
| 35410 | Бичиг хэргийн материал | 425,700.00 | 619,500.00 |
| 35420 | Аж ахуйн материал | 36,395,455.00 | 50,532,383.00 |
| 35430 | Сэлбэг хэрэгсэл | 00.00 | 8,750,000.00 |
| 35440 | Түлш, шатах тослох материал | 5,100,020.00 | 2,900,000.00 |
| 35470 | Бусад хангамжийн материал | 15,439,581.80 | 15,439,581.80 |
| 35600 | Мал амьтад | 11,800,000.00 | 11,800,000.00 |
| **36** | **НӨӨЦИЙН БАРАА** | 5,000,000.00 | 5,000,000.00 |
| 36800 | Бусад эргэлтийн хөрөнгө /ТӨҮГ/ | 5,000,000.00 | 5,000,000.00 |
| **2** | **ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН** | **1,600,322,761.25** | **1,696,014,704.54** |
| **39** | **ҮНДСЭН ХӨРӨНГӨ** | 1,600,322,761.25 | 1,696,014,704.54 |
| **392** | **Биет хөрөнгө** | 1,566,317,736.37 | 1,662,197,179.66 |
| 39201 | Барилга, байгууламж, орон сууц | 1,637,324,995.00 | 1,650,724,995.00 |
| 39203 | Авто-тээврийн хэрэгсэл | 94,466,943.00 | 115,644,377.00 |
| 39205 | Машин тоног төхөөрөмж (компьютер) | 136,133,945.50 | 148,295,977.50 |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 10,985,114.00 | 10,985,114.00 |
| 39214 | Бусад үндсэн хөрөнгө | 96,761,000.00 | 239,951,286.00 |
| 39217 | Ном | 202,200.00 | 202,200.00 |
| **393** | **Биет бус хөрөнгө** | 34,005,024.88 | 33,817,524.88 |
| 39301 | Програм хангамж | 3,827,000.00 | 3,827,000.00 |
| 39303 | Бусад биет бус хөрөнгө | 33,684,400.00 | 33,684,400.00 |
| **3** | **НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II** | **1,677,732,218.05** | **1,794,304,869.34** |
| **4** | **НИЙТ ӨР ТӨЛБӨР** | **18,489,391.00** | **00.00** |
| **41** | **БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР** | 18,489,391.00 | 00.00 |
| **413** | **Өглөг** | 18,489,391.00 | 00.00 |
| 41320 | Бараа үйлчилгээний зардлын өглөг | 18,489,391.00 | 00.00 |
| **5** | **ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН** | **1,659,242,827.05** | **1,794,304,869.34** |
| **51** | **Засгийн газрын хувь оролцоо** | 1,659,242,827.05 | 1,794,304,869.34 |
| 511 | Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан | 493,398,105.90 | 493,398,105.90 |
| 51101 | Өмч: - төрийн | 493,398,105.90 | 493,398,105.90 |
| **512** | **Хуримтлагдсан үр дүн** | -64,200,794.84 | 70,861,247.45 |
| 51220 | Тайлант үеийн үр дүн | 00.00 | 135,062,042.29 |
| 51300 | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 1,230,045,515.99 | 1,230,045,515.99 |
| **6** | **ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V** | **1,677,732,218.05** | **1,794,304,869.34** |

### 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/Төгрөгөөр/

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)** | **902,571,094.00** | **1,001,898,772.00** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **36,570,000.00** | **181,304,752.00** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | 36,570,000.00 | 181,304,752.00 |
| 120004 | Төсөв байгууллагын өөрийн орлого | 36,570,000.00 | 181,304,752.00 |
| 1200045 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого | 36,570,000.00 | 181,304,752.00 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **866,001,094.00** | **820,594,020.00** |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 5,445,794.00 | 205,634,920.00 |
| 131101 | Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж | 600,000.00 | 00.00 |

| | | | |
|---|---|---|---|
| 131103 | ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 00.00 | 202,930,800.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 3,603,434.00 | 2,529,120.00 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 1,242,360.00 | 175,000.00 |
| **1320** | **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | 860,555,300.00 | 614,959,100.00 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 860,555,300.00 | 614,959,100.00 |
| **2** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН** | **879,585,823.99** | **866,836,729.71** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **692,722,023.99** | **804,684,120.71** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 578,983,949.99 | 761,632,045.71 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 247,791,526.00 | 274,481,587.00 |
| 210101 | Үндсэн цалин | 247,791,526.00 | 274,481,587.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 32,949,403.00 | 32,149,883.00 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 23,050,903.00 | 22,229,400.00 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 2,474,700.00 | 2,501,500.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 1,979,700.00 | 2,001,200.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 494,900.00 | 500,300.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 4,949,200.00 | 4,917,483.00 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 12,471,050.00 | 50,462,420.00 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 4,000,000.00 | 6,200,000.00 |
| 210302 | Түлш, халаалт | 8,471,050.00 | 44,262,420.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 76,791,981.00 | 49,963,970.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 6,512,278.00 | 5,873,250.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 37,048,483.00 | 7,814,800.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 3,819,500.00 | 4,194,800.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 7,660,500.00 | 7,660,500.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 13,392,620.00 | 24,420,620.00 |
| 210408 | Бараа материал акталсны зардал | 8,358,600.00 | 00.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 5,840,500.00 | 3,185,500.00 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 5,690,500.00 | 375,000.00 |
| 210603 | Хөдөлмөр хамгааллын хэрэглэл | 00.00 | 900,000.00 |
| 210604 | Урсгал засвар | 150,000.00 | 1,910,500.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 2,000,000.00 | 2,000,000.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 2,000,000.00 | 2,000,000.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 14,754,998.00 | 212,332,618.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 13,694,758.00 | 211,397,433.00 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 75,240.00 | 77,385.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 150,000.00 | 282,300.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 55,000.00 | 75,000.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 430,000.00 | 500,500.00 |
| 210807 | Газрын төлбөр | 350,000.00 | 00.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 186,384,491.99 | 137,056,067.71 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 97,146,510.00 | 42,043,809.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 1,397,006.00 | 774,450.00 |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 87,840,975.99 | 94,237,808.71 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 113,738,074.00 | 43,052,075.00 |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 1,500,000.00 | 30,736,153.00 |
| 213204 | Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал | 500,000.00 | 1,000,000.00 |

| | | | |
|---|---|---|---|
| 213207 | Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж | 00.00 | 22,322,800.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 1,000,000.00 | 7,413,353.00 |
| **2134** | **Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт** | 112,238,074.00 | 12,315,922.00 |
| 213403 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 112,238,074.00 | 12,315,922.00 |
| **22** | **ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ** | **186,863,800.00** | **62,152,609.00** |
| **2200** | **Дотоод эх үүсвэрээр** | 186,863,800.00 | 62,152,609.00 |
| 223001 | Бусад хөрөнгө | 186,863,800.00 | 62,152,609.00 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)** | **22,985,270.01** | **135,062,042.29** |
| **225** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН** | 1,260,000.00 | 00.00 |
| 225001 | Үндсэн хөрөнгө худалдсаны гарз | 1,260,000.00 | 00.00 |
| **5** | **НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)** | **21,725,270.01** | **135,062,042.29** |

**2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан**

**/Төгрөгөөр/**

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ** | | |
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)** | **866,001,094.00** | **820,594,020.00** |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **866,001,094.00** | **820,594,020.00** |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 5,445,794.00 | 205,634,920.00 |
| 131101 | Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж | 600,000.00 | 00.00 |
| 131103 | ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 00.00 | 202,930,800.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 3,603,434.00 | 2,529,120.00 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 1,242,360.00 | 175,000.00 |
| **1320** | **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | 860,555,300.00 | 614,959,100.00 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 860,555,300.00 | 614,959,100.00 |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)** | **519,247,294.00** | **723,827,020.00** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **519,247,294.00** | **723,827,020.00** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **405,509,220.00** | **680,853,548.00** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 247,791,526.00 | 274,395,870.00 |
| 210101 | Үндсэн цалин | 247,791,526.00 | 233,931,338.00 |
| 210102 | Нэмэгдэл | 00.00 | 32,541,326.00 |
| 210104 | Урамшуулал | 00.00 | 7,923,206.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 32,949,403.00 | 32,235,600.00 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 23,050,903.00 | 22,229,400.00 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 2,474,700.00 | 2,501,500.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 1,979,700.00 | 2,001,200.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 494,900.00 | 500,300.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 4,949,200.00 | 5,003,200.00 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 11,800,000.00 | 15,400,000.00 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 4,000,000.00 | 6,200,000.00 |
| 210302 | Түлш, халаалт | 7,600,000.00 | 9,000,000.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 200,000.00 | 200,000.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 36,483,776.00 | 43,985,500.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 4,696,700.00 | 6,150,400.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 18,807,076.00 | 23,264,800.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 3,819,500.00 | 4,194,800.00 |
| 210404 | Ном, хэвлэл | 00.00 | 15,000.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 7,660,500.00 | 7,660,500.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 1,500,000.00 | 2,700,000.00 |

| | | | |
|---|---|---|---|
| **2105** | **Нормативт зардал** | 00.00 | 1,500,000.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 00.00 | 1,500,000.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 5,340,500.00 | 28,057,500.00 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 2,340,500.00 | 505,000.00 |
| 210603 | Хөдөлмөр хамгааллын хэрэглэл | 1,000,000.00 | 1,000,000.00 |
| 210604 | Урсгал засвар | 2,000,000.00 | 26,552,500.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 2,000,000.00 | 2,000,000.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 2,000,000.00 | 2,000,000.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 42,166,655.00 | 237,079,078.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 41,106,415.00 | 235,814,960.00 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 75,240.00 | 77,385.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 150,000.00 | 282,300.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 55,000.00 | 75,000.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 430,000.00 | 500,500.00 |
| 210807 | Газрын төлбөр | 350,000.00 | 328,933.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 26,977,360.00 | 46,200,000.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 24,777,360.00 | 45,000,000.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 2,200,000.00 | 1,200,000.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **113,738,074.00** | **42,973,472.00** |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 1,500,000.00 | 30,657,550.00 |
| 213204 | Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал | 500,000.00 | 1,000,000.00 |
| 213207 | Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж | 00.00 | 22,322,800.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 1,000,000.00 | 7,334,750.00 |
| **2134** | **Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт** | 112,238,074.00 | 12,315,922.00 |
| 213403 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 112,238,074.00 | 12,315,922.00 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)** | **346,753,800.00** | **96,767,000.00** |
| **5** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)** | **346,753,800.00** | **96,767,000.00** |
| **22** | **ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ** | **346,753,800.00** | **96,767,000.00** |
| **2200** | **Дотоод эх үүсвэрээр** | 346,753,800.00 | 96,767,000.00 |
| 223001 | Бусад хөрөнгө | 279,203,800.00 | 88,142,000.00 |
| 225106 | Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал | 67,550,000.00 | 8,625,000.00 |
| **6** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)** | **-346,753,800.00** | **-96,767,000.00** |
| **8** | **НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)** | 00.00 | 00.00 |
| **9** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | 00.00 | 00.00 |
| **10** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | 00.00 | 00.00 |

### 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

**/Төгрөгөөр/**

| Код | Үзүүлэлт | Засгийн газрын оруулсан капитал | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан дүн | Засгийн газрын хувь оролцооны нийт дүн |
|---|---|---|---|---|---|
| C01 | **2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | 493,398,105.90 | 1,230,045,515.99 | -47,598,178.54 | 1,675,845,443.35 |
| C02 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| C03 | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **493,398,105.90** | **1,230,045,515.99** | **-47,598,178.54** | 1,675,845,443.35 |
| C07 | Тайлант үеийн үр дүн | 00.00 | 00.00 | -9,729,067.92 | -9,729,067.92 |
| C08 | **2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **493,398,105.90** | **1,230,045,515.99** | **-64,200,794.84** | 1,659,242,827.05 |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| D01 | **2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **493,398,105.90** | **1,230,045,515.99** | **-64,200,794.84** | 1,659,242,827.05 |
| D02 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| D03 | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **493,398,105.90** | **1,230,045,515.99** | **-64,200,794.84** | 1,659,242,827.05 |
| D08 | Тайлант үеийн үр дүн | 00.00 | 00.00 | 135,062,042.29 | 135,062,042.29 |
| D09 | **2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **493,398,105.90** | **1,230,045,515.99** | **70,861,247.45** | 1,794,304,869.34 |

**2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан**

**/Төгрөгөөр/**

| ҮЗҮҮЛЭЛТ | ТАЙЛАНТ ОНЫ | | ЗӨРҮҮ | |
|---|---|---|---|---|
| | ТӨЛӨВЛӨГӨӨ | ГҮЙЦЭТГЭЛ | Дүн | Хувь |
| **I. НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | **614,959,100.00** | **602,643,178.00** | **12,315,922.00** | **98.0** |
| **УРСГАЛ ЗАРДЛЫН ДҮН** | **509,318,200.00** | **507,921,178.00** | **1,397,022.00** | **99.7** |
| **Бараа, үйлчилгээний зардал** | **480,395,400.00** | **478,999,628.00** | **1,395,772.00** | **99.7** |
| **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | **275,021,972.00** | **274,395,870.00** | **626,102.00** | **99.8** |
| Үндсэн цалин | 234,557,440.00 | 233,931,338.00 | 626,102.00 | 99.7 |
| Нэмэгдэл | 32,541,326.00 | 32,541,326.00 | - | 100.0 |
| Урамшуулал | 7,923,206.00 | 7,923,206.00 | - | 100.0 |
| **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | **32,235,600.00** | **32,235,600.00** | **-** | **100.0** |
| Тэтгэврийн даатгал | 22,229,400.00 | 22,229,400.00 | - | 100.0 |
| Тэтгэмжийн даатгал | 2,501,500.00 | 2,501,500.00 | - | 100.0 |
| ҮОМШӨ ний даатгал | 2,001,200.00 | 2,001,200.00 | - | 100.0 |
| Ажилгүйдлийн даатгал | 500,300.00 | 500,300.00 | - | 100.0 |
| Эрүүл мэндийн даатгал | 5,003,200.00 | 5,003,200.00 | - | 100.0 |
| **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | **15,400,000.00** | **15,400,000.00** | **-** | **100.0** |
| Гэрэл цахилгаан | 6,200,000.00 | 6,200,000.00 | - | 100.0 |
| Түлш, халаалт | 9,000,000.00 | 9,000,000.00 | - | 100.0 |
| Цэвэр, бохир ус | 200,000.00 | 200,000.00 | - | 100.0 |
| **Хангамж, бараа материалын зардал** | **42,790,700.00** | **42,790,700.00** | **-** | **100.0** |
| Бичиг хэрэг | 6,150,400.00 | 6,150,400.00 | - | 100.0 |
| Тээвэр (шатахуун) | 22,100,000.00 | 22,100,000.00 | - | 100.0 |
| Шуудан холбоо, интернэтийн төлбөр | 4,164,800.00 | 4,164,800.00 | - | 100.0 |
| Ном, хэвлэл | 15,000.00 | 15,000.00 | - | 100.0 |
| Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 7,660,500.00 | 7,660,500.00 | - | 100.0 |
| Бага үнэтэй, түргэн элэгдэх, аж ахуйн эд зүйлс | 2,700,000.00 | 2,700,000.00 | - | 100.0 |
| **Нормативт зардал** | **1,500,000.00** | **1,500,000.00** | **-** | **100.0** |
| Нормын хувцас зөөлөн эдлэл | 1,500,000.00 | 1,500,000.00 | - | 100.0 |
| Эд хогшил худалдан авах | 30,102,500.00 | 30,102,500.00 | - | 100.0 |
| Багаж, техник, хэрэгсэл | 2,550,000.00 | 2,550,000.00 | - | 100.0 |
| Хөдөлмөр хамгааллын хэрэгсэл | 1,000,000.00 | 1,000,000.00 | - | 100.0 |
| Урсгал засвар | 26,552,500.00 | 26,552,500.00 | - | 100.0 |
| **Томилолт, зочны зардал** | **2,000,000.00** | **2,000,000.00** | **-** | **100.0** |
| Дотоод албан томилолт | 2,000,000.00 | 2,000,000.00 | - | 100.0 |
| **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр** | **35,144,628.00** | **34,374,958.00** | **769,670.00** | **97.8** |
| Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 33,880,510.00 | 33,110,840.00 | 769,670.00 | 97.7 |
| Даатгалын үйлчилгээ | 77,385.00 | 77,385.00 | - | 100.0 |
| Тээврийн хэрэгслийн татвар | 282,300.00 | 282,300.00 | - | 100.0 |
| Тээврийн хэрэгслийн оношилгоо | 75,000.00 | 75,000.00 | - | 100.0 |
| Мэдээллийн технологийн зардал | 500,500.00 | 500,500.00 | - | 100.0 |

| | | | | |
|---|---|---|---|---|
| Газрын төлбөр | 328,933.00 | 328,933.00 | - | 100.0 |
| **Бараа үйлчилгээний бусад зардал** | **46,200,000.00** | **46,200,000.00** | **-** | **100.0** |
| Бараа үйлчилгээний бусад зардал | 45,000,000.00 | 45,000,000.00 | - | 100.0 |
| Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 1,200,000.00 | 1,200,000.00 | - | 100.0 |
| **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **28,922,800.00** | **28,921,550.00** | **1,250.00** | **100.0** |
| Бусад урсгал шилжүүлэг | 28,922,800.00 | 28,921,550.00 | 1,250.00 | 100.0 |
| Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал | 1,000,000.00 | 1,000,000.00 | - | 100.0 |
| Тэтгэвэрт гарахад нь олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж | 22,322,800.00 | 22,322,800.00 | - | 100.0 |
| Нэг удаагийн тэтгэмж урамшуулал | 5,600,000.00 | 5,598,750.00 | 1,250.00 | 100.0 |
| **ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ** | **105,640,900.00** | **94,722,000.00** | **10,918,900.00** | **89.7** |
| Дотоод эх үүсвэрээр | 105,640,900.00 | 94,722,000.00 | 10,918,900.00 | 89.7 |
| Бусад хөрөнгө | 105,640,900.00 | 94,722,000.00 | 10,918,900.00 | 89.7 |
| **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | **614,959,100.00** | **602,643,178.00** | **12,315,922.00** | **98.0** |
| **ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | **614,959,100.00** | **602,643,178.00** | **12,315,922.00** | **98.0** |
| Орон нутгийн төсвөөс | 614,959,100.00 | 602,643,178.00 | 12,315,922.00 | 98.0 |
| Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | 0 | 0 | 0 | 0 |
| Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | 0 | 0 | 0 | 0 |

**2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан**

**/Төгрөгөөр/**

| | ЗАРДЛЫН ЗҮЙЛ | | ТАЙЛАНТ ОНЫ | |
|---|---|---|---|---|
| ДАНС | ҮЗҮҮЛЭЛТ | МӨР | ТӨЛӨВЛӨГӨӨ | ГҮЙЦЭТГЭЛ |
| | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | | 0 | 0 |
| 2 | I. НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН | | 205634920 | 205634920 |
| 21 | УРСГАЛ ЗАРДЛЫН ДҮН | | 205634920 | 205634920 |
| 210 | Бараа, үйлчилгээний зардал | | 203898920 | 203898920 |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | | 1194800 | 1194800 |
| 210402 | Тээвэр (шатахуун) | | 1164800 | 1164800 |
| 210403 | Шуудан холбоо, интернэтийн төлбөр | | 30000 | 30000 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр | | 202704120 | 202704120 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | | 202704120 | 202704120 |
| | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | | **1736000** | **1736000** |
| 2132 | Бусад урсгал шилжүүлэг | | 1736000 | 1736000 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж урамшуулал | | 1736000 | 1736000 |
| | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | | **205634920** | **205634920** |
| 1311 | Нэмэлт санхүүжилтийн орлого | | 205634920 | 205634920 |
| 131103 | ЗГНХ, Засаг даргын нөөц хөрөнгө түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс зохих байгууллагын шийдвэрийн дагуу тухай төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | | 202930800 | 202930800 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчаас төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | | 2529120 | 2529120 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажилагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | | 175000 | 175000 |
| 4 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | | 0 | 0 |
| 5 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | | 0 | 0 |

## 3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

### 3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

***Байгууллагын үйл ажиллагааны чиглэл, зорилго, зорилтын талаар:*** Эрдэнэбулган сумын ЗДТГ нь тухайн орон нутагт хууль журамд заасан чиг үүрийг орон нутагт хэрэгжүүлэх, ард иргэдийг мэдээллээр хангах үндсэн чиг үүрэгтэй ажиллаж байна. 2022 онд "Төрийн албыг иргэдэд хурдан шуурхай, тэгш, хүртээмжтэй цаг хугацаанд нь чанартай хүргэх" гэсэн зорилго тавьж, түүнийгээ биелүүлэхийн тулд дараах зорилтуудыг дэвшүүлэн ажилласан байна. Үүнд:

1. Албан хаагчдын мэдлэг ур чадварыг дээшлүүлэх, аюулгүй байдал хууль ёсны эрх ашгийг хамгаалах

2. Үйл ажиллагаандаа мэдээллийн дэвшилтэт технологийг нэвтрүүлж шуурхай байдлыг хангах

3. Байгууллагын техник хэрэгслийн ашиглалтыг сайжруулах, хариуцагчтай болгож, бүтээн байгуулалтын ажлуудад бүрэн ашиглаж хөрөнгө оруулалтын ажлыг үр дүнтэй зохион байгуулах

4. Иргэдэд үзүүлэх үйлчилгээг чанарт шилжүүлэх шат дамжлагыг бууруулах

5. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих нэрлэсэн жилийн хүрээнд ажлын байр бий болгох

ЗДТГ-ын дарга нь нь сумын Засаг даргатай 2022 оны гүйцэтгэлийн төлөвлөгөө байгуулж, хэрэгжилтийг 92.0 хувьтай биелүүлж ажилласан байна.

### 3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

***Байгууллагын үйл ажиллагаа явуулж буй хууль эрх зүйн орчны талаар:*** *Тус байгууллага нь Төсвийн тухай хууль, Хувь хүний орлогын албан татварын тухай хууль, нийгмийн даатгалын шимтгэлийн тухай хууль, Засаг захиргаа нутаг дэвсгэрийн тухай хууль болон бусад хууль тогтоомж журам зааврыг мөрдөн ажилласан байна.* Тайлант онд Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжсэнтэй холбоотой байгууллагын үйл ажиллагаанд хэмнэлтийн горимыг баримталж ажилласан байна.

***Байгууллагын дотоод хяналтын талаар:*** Засгийн газрын 2011 оны 311 дүгээр тогтоолоор баталсан Аж ахуйн нэгж, байгууллагын үйл ажиллагаанд дотоод хяналт шалгалтыг зохион байгуулах нийтлэг журам"-ийн дагуу Засаг даргын 2021 оны 09 сарын 21 өдрийн А/17 тоот захирамжаар дотоод хяналт хэрэгжүүлэх ажлын хэсгийг 3 хүний бүрэлдэхүүнтэй байгуулсан байна.

Дотоод хяналтын ажлын хэсэг нь 2022 онд хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөө батлуулан, тухайн онд дотоод хяналтыг 12 чиглэлээр гүйцэтгэх төлөвлөгөө гаргах хэрэгжүүлсэн байна. Дотоод хяналтаар илэрсэн зөрчлийг тухай бүр арилгаж ажилласан байна.

Харин санхүүгийн үйл ажиллагаанд дотоод хяналтын нэг, хоёрдугаар үе шатны тогтолцоо бий болсон байна гэж үзлээ. ***Тухайлбал:*** Санхүүгийн үйл ажиллагаанд гүйцэтгэх удирдлага буюу дарга 1 дүгээр гарын үсэг, нягтлан бодогч 2 дугаар гарын үсэг зурж баталгаажуулж гүйцэтгэх удирдлагын хяналтыг хэрэгжүүлж байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна гэж үзлээ.

Тайлант онд дээд шатны төсвийн захирагчийн дотоод аудитын чиг үүрэг хэрэгжүүлэх нэгжээс хяналтыг хэрэгжүүлээгүй тул аудитад ашиглах дотоод аудитын гүйцэтгэл, ажлын үр дүнгийн тайлан зэрэг баримт материал байхгүй байна.

### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Эрдэнэбулган сумын ЗДТГ-ын 2022 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэж, Төсвийн тухай хуулийн 54.4, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8 дугаар зүйлд заасан иж бүрдийн дагуу бэлтгэж толилуулсан байна гэж үзлээ.

Харин төсвийн гүйцэтгэлийн тайланг мөнгөн сууриар бэлтгэж, Төсвийн тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.5 дахь заалтад заасан заалтын дагуу иж бүрэн ирүүлсэн.

**Байгууллагын мөрдөж буй нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийн талаар:** Санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаандаа Хөвсгөл аймгийн Засаг даргын 2019 оны А/375 дугаар захирамжаар баталсан "Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг"-ийг үйл ажиллагаандаа ашиглаж байна. Санхүү, төсөв нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаандаа УСНББОУС, Засгийн газар, Сангийн яамнаас гаргасан журам, зааврыг мөрдөж ажилласан байна.

### 3.4 Санхүүгийн тайлангийн тодруулга

Эрдэнэбулган сумын Засаг даргын тамгын газрын 2022 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 116,572.7 мянган төгрөгөөр буюу 6.9 хувиар өссөн байна.

*Хүснэгт 1.* Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөгөөр/

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өөрчлөлт |
|---|---|---|---|
| Б | 1 | 2 | 3=2-1 |
| Мөнгөн хөрөнгө | | | |
| Авлага | 1,250.0 | 1,250.0 | - |
| Урьдчилгаа | | | - |
| Бараа материал | 71,159.5 | 92,040.2 | 20,880.7 |
| Үндсэн хөрөнгө | 1,600,322.8 | 1,696,014.7 | 95,691.9 |
| **Нийт хөрөнгө** | 1,677,732.2 | 1,794,304.9 | 116,572.7 |
| Өр төлбөр | 18,489.4 | - | (18,489.4) |
| Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/ | 1,659,242.8 | 1,794,304.9 | 135,062.0 |
| **Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн** | 1,677,732.2 | 1,794,304.9 | 116,572.7 |

Мөнгөн хөрөнгө дансны үлдэгдэл өмнөх он болон тайлант онд үлдэгдэлгүй байна.

Авлагын дансны үлдэгдэл 1,250.0 мянган төгрөг нь өмнөх онд үүссэн малын авлага байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 92,040.2 мянган төгрөг болж 20,880.7 мянган төгрөгөөр өссөн нь түлш, шатах тосох материалын үнэ өссөнөөс шалтгаалжээ.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 1,696,014.7 мянган төгрөг болж 95,691.9 мянган төгрөгөөр өссөн байна. Үндсэн хөрөнгийн данс нь үнэ төлбөргүй шилжүүлэн авсан 181,304.8 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө, урсгал төсвийн худалдан авсан 8,650.0 мянган төгрөгийн биет бус хөрөнгө нийт 95,691.9 мянган төгрөгөөр нэмэгдэж. тайлант үеийн элэгдлийн зардал 94,237.8 мянган төгрөгөөр хасагдсан байна.

Өр төлбөр дансны үлдэгдэл 0.0 төгрөг болж өр төлбөр буурсан байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 1,749,304.9 мянган төгрөг болж, тайлант үеийн үр дүн 135,062.0 мянган төгрөгөөр нэмэгдсэн байна.

### 3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### 3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2022 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 599,847.7 мянган төгрөгөөр, нийт зарлагыг 599,847.7 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Тайлант онд Эрдэнэбулган сумын Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2021 оны 12 дугаар сарын 17-ны өдрийн 7 дугаар тогтоолоор Төсөв захирагчийн хэрэгжүүлэх 3 хөтөлбөрийн 9 арга хэмжээг санхүүжүүлэхээр анх 561,414.0 мянган төгрөгийн төсөв баталснаас дээд шатны төсөв захирагчаас 117,768.2 мянган төгрөг, сумын орлогоос 319,803.8 мянган төгрөг, давсан орлогоос 14,332.0 мянган төгрөг, урьд оны үлдэгдлээс 109,510.0 мянган төгрөгөөр санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Эрдэнэбулган сумын Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2022 оны 6 дугээр сарын 30-ны өдрийн 3 дугаар тогтоолоор Төсөв захирагчийн хэрэгжүүлэх 3 хөтөлбөрийн 9 арга хэмжээг санхүүжүүлэхээр анх баталсан төсвийг 15,767.6 мянган төгрөгөөр нэмэгдүүлж 577,181.6 мянган төгрөгийн төсөв батлалснаас дээд шатны төсөв захирагчаас 3,576.1 мянган төгрөг, 12,191.5 мянган төгрөгийг урьд оны үлдэгдлээс санхүүжүүлэхээр тодотгосон байна.

### 3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Гүйцэтгэлээр орон нутгийн төсвөөс 602,643.2 мянган төгрөгийн санхүүжилт авч, урсгал үйл ажиллагаанд 590,327.3 мянган төгрөгийг зарцуулж 12,315.9 мянган төгрөгийг орон нутгийн төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 590,327.3 мянган төгрөг буюу 98.5 хувьтай байгаа нь үндсэн цалингийн зардлыг 626.1 мянган төгрөгөөр, нэг удаагийн тэтгэмж урамшууллын зардлыг 1.3 мянган төгрөгөөр, орон нутгийн хөрөнгө оруулалтын зардлыг 10,918.9 мянган төгрөгөөр, бусдаар гүйцэтгүүлэх ажил үйлчилгээний зардлыг 769.6 мянган төгрөгөөр тус тус дутуу зарцуулсантай холбоотой байна.

Тухайн байгууллагын төсвийн гүйцэтгэлийг хөтөлбөр, арга хэмжээгээр харуулбал:

Хүснэгт 2. Төсвийн гүйцэтгэл хөтөлбөр, арга хэмжээгээр

/мянган.төгрөгөөр/

| № | Хөтөлбөрийн код, нэр | Зардлын дүн | | Зөрүү | Биелэлт |
|---|---|---|---|---|---|
| | | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | | |
| 1 | 70106 Орон нутгийн гүйцэтгэх удирдлага | 301,097.1 | 300,471.0 | 626.1 | 99.8 |
| 2 | 70503 Орон нутгийн зорилтот хөрөнгө оруулалт | 105,640.9 | 94,722.0 | 10,918.9 | 89.7 |
| 3 | 71413 байгаль орчин хамгаалан нөхөн сэргээх | 32,823.3 | 32,053.7 | 769.7 | 97.7 |
| | **Нийт дүн** | **468,484.1** | 456,168.2 | 2,315.9 | 99.8 |

Тайлант онд 602,643.2 мянган төгрөгийн санхүүжилт авч, урсгал үйл ажиллагаанд 590,327.3 мянган төгрөгийг зарцуулж 12,315.9 мянган төгрөгийг орон нутгийн төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

### 3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т "нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна" гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтээр засаг даргын нөөц хөрөнгө түүнтэй адилтгах нөөц хөрөнгөөс 202,930.8 мянган төгрөг, дээд шатны төсөв захирагчаас 2,529.1 мянган төгрөг, төсөвт байгууллагын үндсэн үйл ажиллагааны орлогоос 175.0 мянган төгрөг нийт 205,634.9 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлжээ.

Үүнээс тээвэр шатахууны зардалд 1,164.8 мянган төгрөг, бусдаар гүйцэтгүүлэх ажил үйлчилгээний зардалд 202,704.1 мянган төгрөг, нэг удаагийн тэтгэмжийн зардалд 1,736.0 мянган төгрөг нийт 205,634.9 мянган төгрөгийг зарцуулжээ.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

### *3.5.4 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн*

2022 онд гадаад, дотоодын эх үүсвэрээр ямар нэгэн төсөл хөтөлбөр хэрэгжээгүй байна.

# 4. АУДИТЫН ТАЙЛАН

## 4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д "Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана." гэж заасны дагуу Эрдэнэбулган сумын ЗДТГ-ын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн байгууллагын үйл ажиллагааг сайжруулахтай холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор С.Гансүх гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Б.Тэгшдэлгэр, дарга тэргүүлэх аудитор А.Эрдэнэбаатар нар хэрэгжүүлсэн.

Эрдэнэбулган сумын ЗДТГ-ын 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төрийн аудитын газарт 2023 оны 01 дүгээр сарын 23-ны өдрийн 3/25 дугаартай албан бичгээр ирүүлсэн байна.

## 4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр өмнөх оны үр дүнгийн тайлангийн нийт зардлын дүнг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг дунд гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2 хувиар тогтоож үр дүнгийн тайлангийн нийт зардлын дүн 896,835.8 мянган төгрөгөөс тооцож 17,936.7 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 80 хувиар буюу 14,349.3 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

## 4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор тус байгууллага нь тайлант онд нийт 12,315.9 мянган төгрөгийг цалингийн зардал, хөрөнгийн зардал, бараа үйлчилгээний бусад зардал, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний зардлаас хэмнэж ажилласан байна.

Тус байгууллагад Төрийн хэмнэлтийн тухай хууль тогтоомжийн хэрэгжилттэй холбоотой нийт 29 асуудлаар горим сорилыг хэрэгжүүлсэн. Горим сорилыг хэрэгжүүлэх явцад төрийн хэмнэлтийн хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил гараагүй.

## 4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

### 4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан "Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны дансны тухай хуулийн хэрэгжилтийг хянаж үзэхэд мэдээллийг хугацаанд нь 30,785.4 мянган төгрөгийн 10 мэдээллийг хугацаа хоцрон оруулж, бусад мэдээллийг хугацаанд нь мэдээлж ажилласан байна.

Шийдвэрлэсэн нь: Зөвлөмж өгөх

### 4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Тус байгууллагын худалдан авах ажиллагааны баримт материалыг хянаж үзэхэд алдаа зөрчилтэй асуудал илрээгүй. Худалдан авах ажиллагаанд харьцуулалтын аргыг ашиглан бага үнийн санал ирүүлсэн байгууллагуудтай гэрээ хийж бараа материалыг худалдан авсан байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

### 4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

#### 4.5.1 Завсрын аудитын талаар

Эрдэнэбулган сумын ЗДТГ-ын 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд завсрын аудит хийгээгүй болно.

#### 4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн зөвлөмжийг хянаж үзэхэд зөвлөмжийн хэрэгжилтийг биелүүлэн ажилласан байна.

*Хүснэгт 4 Төлбөрийн акт,* албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт /мянган төгрөгөөр/

| Үзүүлэлт | Өмнөх аудитын үзүүлэлт | | Биелэлт | | |
|---|---|---|---|---|---|
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Хувь |
| Акт | | | | | |
| Албан шаардлага | 1 | 36,500.0 | 1 | 36,500.0 | 100 |
| Зөвлөмж | 2 | 363,500.0 | 1 | 363,500.0 | 100 |
| **Нийт дүн** | **2** | **400,000.0** | **2** | **400,000.0** | **100** |

### 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар нэмэлт санхүүжилтийн дансны зарцуулалттай холбоотой асуудал байна.

## 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 599.4 мянган төгрөгийн алдаа, зөрчил илэрсэн. Аудитаар 599.4 мянган төгрөгийн зөрчилд 1 зөвлөмж өгсөн.

### 5.1 Төлбөрийн акт

Аудитаар төлбөрийн акт тогтоогоогүй.

### 5.2 Албан шаардлага

Албан шаардлага хариуцлага тооцох санал хүргүүлээгүй.

### 5.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дараалаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

***1. Зардлын данстай холбоотой асуудал***

***<u>Илрүүлэлт</u>:***

Эрдэнэбулган сумын Засаг даргын Тамгын газар нь тайлант онд 8,700,000 төгрөгийн шатахууны зардлыг түлж халаалтын зардлаар бүртгэж, тайлагнасан. Энэ нь Сангийн сайдын 2021 оны 190 дүгээр тушаалаар баталсан “Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар”-тай нийцэхгүй байна

***Өгсөн зөвлөмж*:**

Сангийн сайдын 2021 оны 190 дүгээр тушаалаар баталсан “Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар”-ыг мөрдөж ажиллах зөвлөмж өгөх.

***2. Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой асуудал***

***Илрүүлэлт:***

Шилэн дансны дансны тухай хуулийн хэрэгжилтийг хянаж үзэхэд мэдээллийг хугацаанд нь 30,785.4 мянган төгрөгийн 10 мэдээллийг хугацаа хоцрон мэдээлсэн байна. Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 6.4 “Энэ хуулийн 3.1.1, 3.1.2 –т заасан байгууллага дараах мэдээллийг долоо хоногийн дотор мэдээлнэ...” заалттай нийцэхгүй байна

***Өгсөн зөвлөмж*:**

Шилэн дансны тухай хуульд заасан мэдээллийг хугацаанд нь байршуулж байх.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

### Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

| Алдааны товч утга | Нийт алдаа | | Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан | | Буруу тусган илэрхийлсэн | | Үүнээс | | | | Зөвлөмж | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | Залруулсан | | Залруулаагүй | | | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Эрдэнэбулган сумын Засаг даргын Тамгын газар нь тайлант онд 8,700,000 төгрөгийн шатахууны зардлыг түлж халаалтын зардлаар бүртгэж, тайлагнасан байна. | 1 | 8,700.0 | | | 1 | 8,700.0 | | | 1 | 8,700.0 | | |
| **Дүн** | **1** | **8,700.0** | | | **1** | **8,700.0** | | | **1** | **8,700.0** | | |

**Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

/мянган төгрөгөөр/

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил | | | | | | | | |
| Шилэн дансны дансны тухай хуулийн хэрэгжилтийг хянаж үзэхэд мэдээллийг хугацаанд нь 30,785.4 мянган төгрөгийн 10 мэдээллийг хугацаа хоцрон мэдээлсэн байна. | 1 | 30,785.4 | | | | | 1 | 30,785.4 |
| **Дүн** | **1** | **30,785.4** | | | | | **1** | **30,785.4** |
| Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил | | | | | | | | |
| Дүн | | | | | | | | |
| **Нийт дүн** | **1** | **30,785.4** | | | | | **1** | **30,785.4** |